



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2021 онд: 5.1%,  
Инфляци: 2021 онд: 8.2%,  
Урсгал тэнцэл: 2021 онд: -8.3%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2020 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2021 онд: 6%  
Инфляци: 2021 онд: 5.5%,  
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2021 онд: -13.5%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2020 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3ax1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 10-р сарын байдлаар (1548) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 41 хувиар өссөн бол, зарлага 12.8 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1548 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 52.5 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас 0.03 төгрөгөөр нэмэгджээ.**

Аравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс -4.63 төгрөгөөр буурч, өмнөх сартай харьцуулахад 0.03 төгрөгөөр нэмэгдэж 2848.97 төгрөг болов. 10-р сард гадаад валютын нөөц 4.2 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 0.47 оны эхнээс 7.34 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 12.84 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




**Инфляцийн түвшин 9.7%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2021 оны 10-р сарын байдлаар өмнөх сараас 0.5 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 9.7 хувиар, оны эхнээс 9.7 хувь өсөв. Инфляцын түвшин 2021 оны 10 дугаар сард улсын хэмжээнд хүнсний бараа, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ тус тус өссөн байна.




**Гадаад худалдааны тэнцэл 1878 сая.ам долларын ашигтай гарав.**

2021 оны аравдугаар сард нийт барааны эргэлт 13,169 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 26.3 хувиар нэмэгдсэн бол экспорт өмнөх сараас 25.6 хувь нэмэгдэж, импорт өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 1878 сая ам.долларын ашигтай гарав.



## 10-Р САРЫН ОНЦЛОХ: ДНБ

Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)

ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2020 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар буурсан бол 2021 оны эхний 9 сард 3.6 хувиар өсөв. Улирлын нөлөөллийг арилган тооцсон, ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2021 оны 2 дугаар улиралд өмнөх улирлаас 5.4 хувиар буурсан бол 3 дугаар улиралд 0.4 хувиар өслөө. ДНБ-ий 3.4 хувийн өсөлтийн 20.9 нэгж хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, -9.9 нэгж хувь нь цэвэр экспортод, -7.6 нэгж хувь нь эцсийн хэрэглээнд тус тус ногдож байна. Эцсийн хэрэглээ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) 2021 оны эхний 9 сард 15.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (8.3%) их наяд төгрөгөөр буурсан байна.

## САРЫН ОНЦЛОХ

**УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР 2.1 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРООР НЭМЭГДЖЭЭ**

- Улсын нийт гадаад өр энэ оны эхний хагас жилд 33 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.1 (7 хувь) тэрбум, өмнөх улирлынхаас 471.1 (1.5 хувь) сая ам.доллороор нэмэгдлээ. Нийт гадаад өрийн 36.4 хувь буюу 12 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг, 26.4 хувь буюу 8.7 тэрбум ам.доллар нь бусад салбарынх, 25.6 хувь буюу 8.4 тэрбум ам.доллар нь Засгийн газрынх, 6.7 хувь буюу 2.2 тэрбум ам.доллар нь Монголбанкных, 4.9 хувь буюу 1.6 тэрбум ам.доллар нь төв банкаас бусад хадгаламжийн байгууллагынх аж. Улсын нийт гадаад өр өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэхэд шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг 972.1 (8.8 хувь) сая, бусад салбарынх 588.3 (7.3 хувь) сая, Засгийн газрынх 556 (7 хувь) сая, төв банкных 110.8 (5.3 хувь) сая ам.доллараар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

**ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН ЭКСПОРТЫН ДҮН 97.8 ХУВИАР ӨСӨВ**

Гадаад худалдааны бараа эргэлт 11.5 тэрбум ам.доллар болж, 27.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарав. Гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарав. Монгол Улс 147 оронтой худалдаа хийснээс нийт гадаад худалдааны бараа эргэлт 11.5 тэрбум ам.доллар болоод байна. Үүнийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 27.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Энэ нь өмнөх оны мөн үеэс 59.3 сая ам.доллороор өсөөд байна. Экспорт 6.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар өсөв.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 10-р сар 2021 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 10-р сар 2021 он, Монголбанк
- [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)